



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Вестерн инвестмент фонд ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.

2. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг эрхлэхдээ дахин зөрчил дутагдал гаргасан тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг анхааруулж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Вестерн инвестмент фонд ББСБ” ХХК /О.Алтанзул/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

